


Нэгж хичээлийн сэдэв:
Хөрөг найруулал

**Ээлжит хичээлийн
сэдэв:** Тоочимж эхийн
бүтэц, агуулгын уялдаа
холбоо

Хичээлийн зорилго: Гадаад, дотоод шинжийг
тоочин дүрсэлсэн эхийн бүтэц, агуулгыг задлан
шинжилж, тоочимж эхийн үндсэн шинжийг
таних

Суурилах эх: Хөрөг найруулал



Дараах онолын ойлголтыг дэвтэртээ тэмдэглэж аваарай.

Эхийн бүтэц: Эх цогцолбороос бүтэх бөгөөд эхлэл, гол, төгсгөл гэсэн 3 хэсэгтэй.


Эхийн эхлэл хэсэг: Хэний, юуны тухай тоочин дүрслэх вэ? гэдгээ танилцуулах

Эхийн гол хэсэг: Өгүүлж буй хүн, юм үзэгдлийнхээ дотоод, гадаад шинжийг тоочин дүрслэх

Эхийн төгсгөл хэсэг: Эхлэл, гол хэсгийг дүгнэх

Эхийн агуулгын уялдаа холбоо: Эхийн бүтцийн хэсгүүд хоорондоо уялдаа холбоотой байх бөгөөд “Эх бол агуулгын хувьд нэгэн бүхэл цогц юм.”

Дараах хөрөг
найрууллын
бүтцийн
задлалыг
анхааралтай
уншаад, хэсэг
тус бүрд юуны
тухай
өгүүлснийг
тайлбарлаарай.



А. Эхийн эхлэл хэсгийг олъё.
“Эхлэл хэсэг”-т юуны тухай
өгүүлсэн бэ?

.....

Эхийн гол хэсгийг олъё.
“Гол хэсэг”-т юуны тухай
өгүүлсэн бэ?

.....

Эхийн төгсгөлийг олъё.
“Төгсгөл хэсэг”-т юуны тухай
өгүүлсэн бэ?

.....

Өмнөх үйл
ажиллагаа дээр
тулгуурлаад, хөрөг
найрууллын бүтэц,
агуулгыг хүснэгтээр
харуулаарай.

Хөрөг найруулал бол
тоочимж эхийн
жишээ.

Эхийн бүтэц	Утга агуулга (Юуны тухай бичих вэ?)
Эхлэл хэсэг	
Гол хэсэг	
Төгсгөл хэсэг	

Миний найз

Үнэнийг хэлэхэд надад олон сайн, үнэнч найз бий. Тэд бол манай ангийн охид хөвгүүд. Гэхдээ Удвал миний хамгийн сайн найз, бид хоёр 5 жил гаруй найзалж байна.

Тэр 13 настай. Удвал тийм ч өндөр биш, гэхдээ хэзээд сэтгэл булаам харагддаг. Найз маань долоо хоногт хоёр удаа иог, усан спортоор хичээллэдэг тул бие галбир нь үнэхээр эрүүл, чийрэг, тэгш сайхан. Миний найз шулуун, урт, хүрэндүү үстэй, тунгалаг бор нүдтэй, урт хар сормуустай бөгөөд үргэлж дэгжин хувцасладаг.

Ер нь найз маань үзэсгэлэнтэй, дур булаам охин. Гэхдээ миний бодлоор дотоод гоо сайхан нь бие махбодоос илүү чухал юм. Удвал бол хүмүүжилтэй, хөгжилтэй, сайхан сэтгэлтэй охин. Би авхаалжтай, мэдрэмжтэй, сэргэлэн цовоо, өгөөмөр сайхан сэтгэлтэй найзаараа бахархдаг даа.

Дараах эхийн, утга, бүтцийг
тодорхойлоорой.

Дараах асуултад
хариулж,
тоочимж эхийн
үндсэн шинжийг
тодорхойлоорой.

Хүүрнэмж эх шиг өгүүлбэрүүдийн утга нь нэг нь нөгөөгөөсөө ургаж гарсан шинжтэй байна уу?

Өгүүлбэрийн доторх үгсэд асуулт тавибал ихэвчлэн нэг төрлийн асуултад хариулагдахаар байна уу? Өөр өөр асуултад хариулагдахаар байна уу?

Өгүүлбэрт ямар цэг тэмдэг олон хэрэглэгдэж байна вэ? Учир юу юм бол?